ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Мөст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2022/101/НА/-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2022 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны<br>аудитор: Ч. Мөнхцоож<br>Утас: 99028555<br>цахим хаяг: munhuu8555@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ ........ 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ ........ 3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ ........ 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ ........ 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ ........ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /төгрөгөөр/ ........ 10
3. Аудитын тайлан ........ 10
3.1 Ерөнхий зүйл ........ 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
3.4 Материаллаг байдал ........ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
3.8 Аудитын гол асуудал ........ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 14
4. Аудитын илрүүлэлт ........ 15
4.1 Залруулсан алдаа ........ 15
Аудитаар 53004,8 мянган төгрөгийн алдааг залрууллаа. ........ **Error! Bookmark not defined.**
4.2 Төлбөрийн акт ........ 15
4.3 Албан шаардлага ........ 15
4.4 Зөвлөмж ........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| НА | Нотлох ажил |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.18 № 2/96

танай ____________-ны №______________-т

МӨСТ СУМЫН СУРГУУЛИЙН

ЗАХИРАЛ Л.ТОГТОХБАЯР ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөст сумын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **100,356,142.60** | **130,232,469.75** |
| 33 | **АВЛАГА** | 665,685.17 | 14,800,696.75 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 209,809.17 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 455,876.00 | - |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | | 1,800,696.75 |
| 335 | **Бусад авлага** | - | 13,000,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 13,000,000.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 99,690,457.43 | 115,431,773.00 |
| 351 | **Түүхий эд материал** | 2,233,850.00 | 1,630,926.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 55,000.00 | - |
| 35130 | Эм боох материал | 2,178,850.00 | 1,630,926.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | 3,858,000.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 91,609,607.43 | 103,840,847.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 314,000.00 | 589,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 482,858.00 | 791,058.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 10,000,000.00 | 14,700,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,145,245.00 | 14,093,285.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 72,667,504.43 | 73,667,504.00 |
| 35600 | Мал амьтад | 5,847,000.00 | 6,102,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,786,966,222.71** | **1,936,754,012.21** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,786,966,222.71 | 1,936,754,012.21 |
| 392 | **Биет хөрөнгө** | 1,752,580,849.87 | 1,902,437,146.74 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,894,241,345.57 | 2,134,002,630.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (340,417,054.47) | (400,458,821.19) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,500,000.00 | 21,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (21,500,000.00) | (21,500,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 298,863,129.65 | 338,456,509.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (246,478,090.47) | (268,610,248.79) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 165,547,404.00 | 179,063,723.38 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (97,172,762.28) | (110,621,710.22) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 49,200,000.00 | - |
| 39217 | Ном | 28,796,877.87 | 30,605,063.34 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 34,385,372.84 | 34,316,865.47 |
| 39301 | Програм хангамж | 30,456,716.00 | 30,456,716.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (30,091,343.16) | (30,159,850.53) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 34,020,000.00 | 34,020,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,887,322,365.31** | **2,066,986,481.96** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,887,322,365.31** | **2,066,986,481.96** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,887,322,365.31 | 2,066,986,481.96 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,778,052,567.80 | 1,778,052,567.80 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,778,052,567.80 | 1,778,052,567.80 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | (430,336,894.48) | (250,672,777.83) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (584,348,908.76) | (430,336,894.48) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 154,012,014.28 | 179,664,116.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 539,606,691.99 | 539,606,691.99 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,887,322,365.31** | **2,066,986,481.96** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,406,506,830.43** | **1,419,136,187.85** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **174,513,230.43** | **245,459,169.85** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 133,973,255.50 | 244,459,169.85 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 131,067,655.50 | 244,459,169.85 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,400,000.00 | 500,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 129,667,655.50 | 243,959,169.85 |
| 120009 | Бусад орлого | 2,905,600.00 | |
| 122 | **Тусламжийн орлого** | 40,539,974.93 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 40,539,974.93 | |
| 123 | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | - | 1,000,000.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | - | 1,000,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,231,993,600.00** | **1,173,677,018.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,231,993,600.00 | 1,083,485,400.00 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 48,617,400.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,134,176,200.00 | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 49,200,000.00 | 48,617,400.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 41,574,218.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 37,429,118.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 4,145,100.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,252,031,216.09** | **1,239,472,071.20** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,252,031,216.09** | **1,239,472,071.20** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,189,286,970.30 | 1,163,808,951.81 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **899,620,032.61** | **869,281,336.41** |
| 210101 | Үндсэн цалин | 673,231,755.61 | 607,572,236.41 |
| 210102 | Нэмэгдэл | 167,850,294.00 | 209,854,500 |
| 210104 | Урамшуулал | 58,537,983.00 | 51,854,600 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **114,048,232.17** | **110,084,363.05** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 78,099,980.17 | 74,835,223.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,987,063.00 | 8,812,284.96 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,189,650.40 | 7,049,827.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,797,412.60 | 1,762,456.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,974,126.00 | 17,624,569.92 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **43,284,429.00** | **35,269,436.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,192,229.00 | 9,974,436.00 |
| 210302 | Түлш, халаалт | 31,592,200.00 | 25,295,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,500,000.00 | |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **18,050,462.00** | **19,591,976.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,344,700.00 | 2,012,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,707,162.00 | 4,148,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 373,100.00 | 333,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 59,700.00 | 3,102,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 287,050.00 | 153,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,080,300.00 | 9,690,376.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 4,198,450.00 | 150,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **19,770,232.15** | **30,327,260.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,249,850.00 | 2,033,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,416,405.00 | 28,293,860.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,103,977.15 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,071,872.85 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,071,872.85 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **306,600.00** | **163,200.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 306,600.00 | 163,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,392,000.00** | **2,176,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000,000.00 | 1,456,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 392,000.00 | 720,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **90,743,109.52** | **95,915,380.35** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,585,218.00 | 74,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 149,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 86,157,891.52 | 95,691,380.35 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **62,744,245.79** | **75,663,119.39** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **13,556,900.00** | **53,813,242.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,556,900.00 | 21,907,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 31,905,342.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **49,187,345.79** | **21,849,877.39** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 49,187,345.79 | 21,849,877.39 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 154,475,614.34 | 179,664,116.65 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 463,600.06 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 463,600.06 | |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (463,600.06) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 154,012,014.28 | 179,664,116.65 |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,778,052,567.80** | **540,342,398.80** | **-585,084,615.57** | | 1,733,310,351.03 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 735,706.81 | | 735,706.81 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,778,052,567.80** | **540,342,398.80** | **(584,348,908.76)** | **-** | 1,734,046,057.84 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | 735,706.81 | - | | 735,706.81 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 154,012,014.28 | | 154,012,014.28 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,778,052,567.80** | **539,606,691.99** | **(430,336,894.48)** | **-** | 1,887,322,365.31 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,778,052,567.80** | **539,606,691.99** | **(430,336,894.48)** | - | 1,887,322,365.31 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,778,052,567.80** | **539,606,691.99** | **(430,336,894.48)** | - | 1,887,322,365.31 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 179,664,116.65 | | 179,664,116.65 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,778,052,567.80** | **539,606,691.99** | **(250,672,777.83)** | - | 2,066,986,481.96 |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,239,729,100.00** | **1,175,632,894** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **7,735,500.00** | **6,100,976** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 7,735,500.00 | 5,100,976 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,400,000.00 | 955,876 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,400,000.00 | 500,000 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 455,876 |
| 120009 | Бусад орлого | 6,335,500.00 | 4,145,100 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | - | 1,000,000 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | - | 1,000,000 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,231,993,600.00** | **1,169,531,918** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,134,176,200.00 | 1,083,485,400 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,134,176,200.00 | 1,083,485,400 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 37,429,118 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 37,429,118 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 97,817,400.00 | 48,617,400 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 48,617,400.00 | - |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 49,200,000.00 | 48,617,400 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,190,529,100.00** | **1,175,632,894.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,190,529,100.00** | **1,175,632,894.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,128,240,730.21** | **1,096,111,774.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **910,020,016.61** | **869,039,755** |
| 210101 | Үндсэн цалин | 616,825,291.28 | 607,330,655 |
| 210102 | Нэмэгдэл | 229,386,600.00 | 209,854,500 |
| 210104 | Урамшуулал | 62,358,401.33 | 51,854,600 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,449,724.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **114,896,458.60** | **113,874,467** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 78,312,758.60 | 79,121,267 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,145,900.00 | 8,688,300 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,316,800.00 | 6,950,700 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,829,200.00 | 1,737,700 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,291,800.00 | 17,376,500 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **46,019,729.00** | **39,361,700** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,192,229.00 | 7,308,700 |
| 210302 | Түлш, халаалт | 36,407,500.00 | 30,633,000 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,420,000.00 | 1,420,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,661,500.00** | **12,155,452** |
| 210401 | Бичиг хэрэг | 473,000.00 | 823,420 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,317,700.00 | 2,001,500 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 609,000.00 | 609,000 |
| 210404 | Ном, хэвлэл | 420,500.00 | 3,351,000 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 227,800.00 | 1,101,156 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,613,500.00 | 4,269,376 |
| **2105** | **Нормативт зардал** | **35,448,050.00** | **37,707,200** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,907,700.00 | 644,700 |
| 210502 | Хоол, хүнс | 29,341,750.00 | 34,243,900 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,198,600.00 | 2,818,600 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,007,900.00** | **1,007,900** |
| 210604 | Урсгал засвар | 1,007,900.00 | 1,007,900 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **306,600.00** | **163,200** |
| 210702 | Дотоод албан томилолт | 306,600.00 | 163,200 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,392,000.00** | **5,020,000** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000,000.00 | 4,300,000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 392,000.00 | 720,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,488,476.00** | **17,782,100** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,385,776.00 | 14,500,000 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,102,700.00 | 3,282,100 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **62,288,369.79** | **79,521,119** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,556,900.00 | 57,671,242.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,556,900.00 | 25,765,900 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 31,905,342 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 48,731,469.79 | 21,849,877.39 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 48,731,469.79 | 21,849,877 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **49,200,000.00** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **49,200,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **49,200,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 49,200,000.00 | - |
| 221001 | Их засвар | 49,200,000.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (49,200,000.00) | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** *Төгрөгөөр*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,183,293,600 | 1,134,562,130 | 1,110,752,922 | 1,110,752,922 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,183,293,600 | 1,134,562,130 | 1,110,752,922 | 1,110,752,922 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,160,311,700 | 1,121,005,230 | 1,084,987,022 | 1,084,987,022 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 914,591,100 | 908,570,293 | 869,039,755 | 869,039,755 |
| 210101 | Үндсэн цалин | 620,094,600 | 616,825,291 | 607,330,655 | 607,330,655 |
| 210102 | Нэмэгдэл | 229,386,600 | 229,386,600 | 209,854,500 | 209,854,500 |
| 210104 | Урамшуулал | 65,109,900 | 62,358,401 | 51,854,600 | 51,854,600 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 123,469,800 | 114,896,459 | 113,874,467 | 113,874,467 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,886,100 | 78,312,759 | 79,121,267 | 79,121,267 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,145,900 | 9,145,900 | 8,688,300 | 8,688,300 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,316,800 | 7,316,800 | 6,950,700 | 6,950,700 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,829,200 | 1,829,200 | 1,737,700 | 1,737,700 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,291,800 | 18,291,800 | 17,376,500 | 17,376,500 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47,609,500 | 46,019,729 | 39,361,700 | 39,361,700 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,308,700 | 8,192,229 | 7,308,700 | 7,308,700 |
| 210302 | Түлш, халаалт | 38,880,800 | 36,407,500 | 30,633,000 | 30,633,000 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,420,000 | 1,420,000 | 1,420,000 | 1,420,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,761,500 | 9,761,500 | 6,330,700 | 6,330,700 |
| 210401 | Бичиг хэрэг | 473,000 | 473,000 | 473,000 | 473,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,317,700 | 2,317,700 | 2,001,500 | 2,001,500 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 609,000 | 609,000 | 609,000 | 609,000 |
| 210404 | Ном, хэвлэл | 420,500 | 420,500 | 305,900 | 305,900 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 227,800 | 227,800 | 227,800 | 227,800 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,713,500 | 5,713,500 | 2,713,500 | 2,713,500 |
| **2105** | **Нормативт зардал** | 58,570,600 | 35,448,050 | 36,707,200 | 36,707,200 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,907,700 | 3,907,700 | 644,700 | 644,700 |
| 210502 | Хоол, хүнс | 52,464,300 | 29,341,750 | 34,243,900 | 34,243,900 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,198,600 | 2,198,600 | 1,818,600 | 1,818,600 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,007,900 | 1,007,900 | 1,007,900 | 1,007,900 |
| 210604 | Урсгал засвар | 1,007,900 | 1,007,900 | 1,007,900 | 1,007,900 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 306,600 | 306,600 | 163,200 | 163,200 |
| 210702 | Дотоод албан томилолт | 306,600 | 306,600 | 163,200 | 163,200 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 392,000 | 392,000 | 720,000 | 720,000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 392,000 | 392,000 | 720,000 | 720,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,602,700 | 4,602,700 | 17,782,100 | 17,782,100 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000 | 500,000 | 14,500,000 | 14,500,000 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,102,700 | 4,102,700 | 3,282,100 | 3,282,100 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22,981,900 | 13,556,900 | 25,765,900 | 25,765,900 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,981,900 | 13,556,900 | 25,765,900 | 25,765,900 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,981,900 | 13,556,900 | 25,765,900 | 25,765,900 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,183,293,600 | 1,134,562,130 | 1,110,752,923 | 1,110,752,923 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,134,176,200 | 1,085,444,730 | 1,069,883,323 | 1,069,883,323 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,134,176,200 | 1,085,444,730 | 1,069,883,323 | 1,069,883,323 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 48,617,400 | 48,617,400 | 40,369,600 | 40,369,600 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 48,617,400 | 48,617,400 | 40,369,600 | 40,369,600 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 500,000 | 500,000 | 500,000 | 500,000 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000 | 500,000 | 500,000 | 500,000 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 78 | 78 | 79 | 79 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 41 | 41 | 42 | 42 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 25 | 25 | 25 | 25 |
| 620004 | Гэрээт ажилтан | 11 | 11 | 11 | 11 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 604 | 604 | 591 | 591 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 604 | 604 | 591 | 591 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 604 | 604 | 591 | 591 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **56,435,500.00** | **43,030,094.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **56,435,500.00** | **43,030,094.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 56,435,500.00 | 11,124,752.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,449,724.00 | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,449,724.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 900,000.00 | 5,824,752.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 350,420.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 3,045,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 873,356.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 900,000.00 | 1,555,876.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 1,000,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 49,200,000.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 49,200,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,000,000.00 | 4,300,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000,000.00 | 4,300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,885,776.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,885,776.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 31,905,342.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 31,905,342.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 31,905,342.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,429,900.00** | - |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 3,429,900.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 56,435,500.00 | 43,030,094.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 56,435,500.00 | 43,030,094.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 49,200,000.00 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,455,876.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 37,429,118.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,235,500.00 | 4,145,100.00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мөст сумын ерөнхий боловсролын дунд сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой асуудлаар зөвлөмж хүргүүллээ.

Аудитыг Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны аудитор Ч. Мөнхцоoз 2022 оны 1 дугаар сарын 24-нээс 2021 оны 2 дугаар сарын 13–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 28-ний өдрийн 9 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

БСШУЯ-наас дэвшүүлсэн "Хүүхдийн сурах үйлийг дэмжих, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх...",БСУГ-аас дэвшүүлсэн "...Бүх түвшинд сурлагын чанарыг ахиулах...", сургуулиас дэвшүүлсэн "Багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй хэрэгжүүлж, багш эцэг эх асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах" зорилгыг дэвшүүлэн сургалт хүмүүжлийн ажлаа зохион байгуулжээ.

2021-2022 оны хичээлийн жилд 602 суралцагч үүнээс: өдрөөр 585, дүйцсэн хөтөлбөрөөр 17 суралцагч суралцаж байна. Хамран сургах тойргийн 69 суралцагчаас 1 дүгээр ангид 44 сурагч шинээр элсэн, дотуур байранд 45 сурагч амьдарч байна.

БШУСайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/525, А/292 дугаар тушаалын дагуу хичээл үйл ажиллагааг эхлүүлж, сонгон дугуйлан, хоцрогдол арилгах давтлагууд хуваарийн дагуу хэвийн явагдан шаардлагатай тохиолдолд халдвараас шалтгаалан зарим ангиуд 5:9 зарчмаар хичээллэсэн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2017 оноос хойш шинэчлэлт хийгдээгүй.

2021 онд аймгийн Засаг даргын тамгын газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн болон Засаг даргын дэргэдэх дотоод аудитын албанаас 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн, Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 оны санхүүгийн тайланд аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөст сумын ерөнхий боловсролын дунд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны батлагдсан төсвийн 1132602,8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 22652,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 18121,6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөст сумын ерөнхий боловсролын дунд сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 179664,1 мянган төгрөгөөр буюу 9,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдууд байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант онд авлага өмнөх оноос 14135,0 мянган төгрөгөөр өссөн нь цахим засаглалын хүрээнд Санко маркетинг монголиа ХХК-аас ухаалаг самбар авахаар Аймгийн Засаг даргын А/840 тоот захирамжаар 13,0 сая төгрөг шилжүүлсэн боловч хөрөнгөө он дотроо багтаан нийлүүлээгүйгээс авлага үүссэн байна. Мөн ХАОАТ-т НДШ-д илүү шилжүүлсэн 1800,6 мянган төгрөгийг авлагаар бүртгэн тайлагнасан зэргээр авлага өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 115431,8 мянган төгрөг болж 15741,4 мянган төгрөгөөр буюу15,8 хувиар өссөн байна. Энэ нь үдийн хоол дотуур байрны хоол хүнсний материал, түлшний үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл цэвэр дүнгээр оны эхэнд 1786966.2 мянган төгрөг, оны эцэст 1936754,0 мянган төгрөг болж 149787,8 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тендерт Эх нутгийн уулс ХХК дотуур байрны засвар хийхээр шалгарч 24266,0 төгрөгийн 16 нэрийн 23 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлж 75616,8 мянган төгрөгийн барилгын засвар хийж хүлээлгэн өгсөн, Дотуур байрны гал тогооны барилгын их засварын тендерт Монголиа Бюлдинг консалтинг групп шалгарч 164144,4 мянган төгрөгийн засварын ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгсөн, БСГазраас хөрөнгө оруулалтаар 26299,7 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, ширээ сандал зэрэг эд хогшил, сурах бичиг зэргийг нийлүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд 2544,0 мянган төгрөгийн принтер проектор зэрэг сургалтын техник хэрэгсэл бэлтгэн орлого авч данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Тайлант хугацаандд хөрөнгө акталж данснаас хассан өөрчлөлт гараагүй тул Засгийн газрын оруулсан хөрөнгийн хэмжээ, болон дахин үнэлгээний нэмэгдлийн дүнд өөрчлөлт ороогүй.

Балансын хугацаанд үндсэн хөрөнгө өссөн, авлага нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор тайлангийн үеийн үр дүн 179664,1 мянган төгрөгөөр өсөж хуримтлагдсан үр дүн нэмэгдсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мөст сумын ерөнхий боловсролын дунд сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1437747,2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1437747,2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 1132602,8 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1132602,8 мянган төгрөгийн төсөв баталснаас 1083485,4 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 48617,4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс / тогтмол зардлыг санхүүжүүлэх/, 500,0 мянган төгрөгийг төлбөртэй үйлчилгээний орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1083485,4 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 48617,4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс / тогтмол зардлыг санхүүжүүлэх/, 500,0 мянган төгрөгийн орлого тус тус бүрдүүлснээс 21849,8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 1110753,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1110753,0 мянган төгрөг буюу 98,0 хувьтай байгаа нь Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 13478,6 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 8247,8 мянган төгрөгөөр, томилолтын зардал 123,4 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт дансаар төсвийн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос 1100,0 мянган төгрөг, сурах бичгийн түрээсийн орлогоор 3045,1 мянган төгрөг, БСГазраас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжинд 31905,3 мянган төгрөг, БСГ-аас багш нарын чадавхийг нэмэгдүүлэх, сургалтын орчинг сайжруулах төслийн хүрээнд олгосон 4300,0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангаас "Дөл" тоглолтын хувцас хэрэгсэлд олгосон 1000,0 мянган төгрөг, БСГ-аас Ковид-19 цар тахалын хүрээнд олгосон ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 873,3 мянган төгрөг, мөн хүүхдийн түвшин тогтоох шалгалтын зардалд зориулан олгосон 350,4 мянган төгрөг нийт 43030,1 мянган төгрөгийн орлого орж тус тусын зориулалтын дагуу зарцуулагджээ.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа 143 мэдээллийг хугацаандаа оруулж, 5 мэдээлэл хугацаа хожимдож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Аудитын хугацаанд төсвийн гүйцэтгэлийн улирлын тайлангууд болон цалингийн үардлаас бусад 5,0 сая төгрөгийн үнийн дүнгээс дээших ажил гүйлгээ 11 байгаа бөгөөд эдгээрийг шилэн дансанд хугацаанд нь байршуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Нягтлан бодогч, эд хариуцагч нар холбогдох мэдээллийг санхүүгийн программд үнэн зөв, бүрэн оруулаагүйгээс аж ахуйн нэгж байгууллага болон хувь хүмүүс бүрээр авлага, өглөгийн тооцоог хаах боломжгүй, санхүүгийн тайлангийн уялдаагүй тайлагнадаг зөрчил илэрч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна." гэж заасны дагуу санхүүгийн программд мэдээллийг үнэн зөв шивж оруулах гэсэн зөвлөмж хүргүүлсэн зөвлөмжийн дагуу 4 төрлийн ажил зохион байгуулж үр дүнг тооцсоноор авлагын үлдэгдлийг бүрэн баталгаажуулсан, цалингийн тооцооллын зөрүү тодорхой хэмжээнд арилсан, хоолны материал нийлүүлдэг аж ахуйн нэгжүүдэд тендер зарлах тухай захирлын 2021 оны 8 дугаар сарын 1-ны 49 тоот албан бичгийг сумын Засаг дарга, тамгын газарт хүргүүлж тендерийн зар тараасан зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлжээ. Хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 45 тоот, 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/42 тоот албан бичгээр аймгийн Аудитын газарт хүргүүлжээ. Өмнөх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн гэж үзлээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар түлээ нүүрс, аргалын худалдан авалт зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах, үр дүнг дараагийн аудитаар авч үзэхээр тусгажээ.

. Энэ асуудлаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй өмнөх тайлангийн үед байсан дутагдал байсаар байна. Иймээс аудитаас зөвлөмж хүргүүлж үр дүнг хянахаар шийдвэрлэв.

Бид 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар цахим засаглалын хүрээнд Санко маркетинг монголиа ХХК-аас ухаалаг самбар авахаар Аймгийн Засаг даргын А/840 тоот захирамжаар 13,0 сая төгрөг шилжүүлсэн боловч хөрөнгөө он дотроо багтаан нийлүүлээгүй асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 52910,7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 52910,7 мянган төгрөгийн алдааг залруулж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй зөрчлийг арилгах 1 албан шаардлага, түлш, нүүрсний зарцуулалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах 1 төрлийн зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1.Дотуур байрны гал тогооны их засварын зардлын урьдчилгааг их засварын дүнг капиталжуулахдаа давхар оруулснаас үр дүнгийн тайланд гарз бүртгэсэн

***Шийдвэрлэсэн нь:*** Аудитын явцад 49200.0 мянган төгрөгийн залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг аудитын явцад залруулсан.

2. мөнгөн гүйлгээний тайланд нийт цалингийн дүн 3417,6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн

***Шийдвэрлэсэн нь:*** Аудитын явцад 3417,6 мянган төгрөгийн залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг аудитын явцад залруулсан.

3. Бараа материалын орлого 293,1 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн

***Шийдвэрлэсэн нь:*** Аудитын явцад 293,1 мянган төгрөгийн залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг аудитын явцад залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй. Бид Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн асуудлыг нэгтгэсэн тайлангийн түвшинд үзэх нь зүйтэй гэж үзэв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### *4.4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:* Түлээ нүүрс, аргалын худалдан авалт зарцуулалтад тавих хяналт шаардлага хангахгүй , норм норматив тогтоогүй, хүлээн авахдаа хэмжилт хийгдээгүй, хоол хүнсний материал ихээхэн дүнгээр нөөцөлсөн зэрэг алдаа зөрчилүүд байна.

1.2. *Эрсдэл:* Төсвийн үрэлгэн зарцуулалт үүсэх, Хөрөнгө, өр төлбөр болон өмчийн хувь оролцоо санхүүгийн тайланд зөв дүнгээр тусгасан ба үнэлгээ болон хуваарилалтын батламж мэдэгдэл хэрэгжихгүй байх

1.3. *1.2 Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг мөрдөн түлш, нүүрсийг хүлээн авахад болон түлшний зарцуулалтын зураг авалт хийж, норм тогтоох, тогтоосон нормыг мөрдөх замаар зарцуулалтыг тооцох хэмжих, хүнмсний материалыг их дүнгээр нөөцлөхгүй байх зэргээр ажил гүйлгээ гарсан тухай бүр хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Мөст сумын сургууль | 4 | 52910,7 | 3 | 52910,7 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР 2022,02,13**

**АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН 2022,02,13**

**АУДИТОР: Ч.МӨНХЦООЗ 2022,02,13**

143692
ПЮА0073 9066454